

Хөрөнгө оруулалт, гадаад харилцаа хамтын ажиллагаа

БНХАУ, Бээжин хот, China World зочид буудал, New Horizons Conference room
2014.06.04, 14.00-16.00

Оролцогчид: Улаанбаатар хотын удирдлага, Монгол Наадам Цогцолбор ОНӨТҮГ, Шанхай констракшн групп, Шанхай хотод суугаа Монгол Улсын Консул.

Уулзалтад Монгол талаас:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл
2. Нийслэлийн засаг даргын тамгын газрын дарга Ё.Гэрэлчулуун
3. Нийслэлийн гадаад харилцааны хэлтсийн дарга Д.Наранцэцэг
4. Нийслэлийн гадаад харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Отгонсүрэн
5. Монгол Наадам Цогцолбор ОНӨТҮГ-ийн дарга П.Цогтбаатар
6. Монгол Наадам Цогцолбор ОНӨТҮГ-ийн хөрөнгө оруулалтын зөвлөх Ц.Нямдэлгэр
7. Шанхай хот дахь Монгол Улсын Консулын газрын ерөнхий консул Д.Даваасүрэн

Уулзалтад Хятадын талаас:

1. Шанхай констракшн группын гадаад харилцааны хэлтсийн орлогч захирал Chris Pi,
2. Шанхай констракшн группын гадаад харилцааны хэлтсийн ахлах менежер Martin Zhang

Martin Zhang: Хотын дарга ба түүнтэй хамт яваа төлөөлөгчдийг Хятад Улсын Бээжин хотод тавтай зочилж ажиллахыг хүсээд өөрийн группын видео танилцуулгыг хийв.

Мөн компанийн Монгол оронд хийж гүйцэтгэсэн бүтээн байгуулалтын ажлуудыг товч танилцуулав. Үүнд:

- Буянт-Ухаа спорт цогцолбор;
- Худалдаа Аж Үйлдвэрийн Тэнхимийн Оффисын барилга;
- Ховд аймгийн Дөргөн сумын усан цахилгаан станц; зэргийн бүтээн байгуулснаа танилцуулсан.

Үүний дараа Монгол Улс болон Улаанбаатар хотод явагдаж байгаа бүтээн байгуулалтад идэвхтэй оролцохыг хүсэж байгаагаа илэрхийлэв.


Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл: Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөлт хэтийн төлөвийн талаар товч ярьж, Шанхай СПЕСКО групптэй хамтарч ажиллахад таатай байгаагаа илэрхийлэв.

Ингэж харилцан санал солилцсоны дараа эхлээд Монгол Наадам Цогцолборыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хамтран ажиллах 2 талын ажлын хэсэг гарган ажиллах санал тавив. Үүнийг СПЕСКО группын төлөөлөгч санал нэгтгэйгээр хүлээн авч 15-20 хоногийн дараа СПЕСКО группын төлөөлөгчид Улаанбаатар хотод ирж энэ ажлын талаар тодорхой уулзан ярилцаж хамтран ажиллахаар тохиролцов.

Үүний дараа хотын дарга Э.Бат-Үүл энэ уулзалтыг зохион байгуулж, цаашид хамтран

ажиллах эхлэл тавигдсанд талархаж Улаанбаатар хотын нэрийн өмнөөс жижиг бэлэг дурсгалын зүйлийг СПЕСКО группын төлөөлөгчдөд мөн Шанхай хотод суугаа Монгол Улсын консул Д.Даваасүрэн нарт гардуулав.

Энэ уулзалтын үр дүнд 2014 оны 07 дугаар сар 09-ний өдөр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл болон Шанхай констракшн групптэй Монгол наадам цогцолбор төслийг хэрэгжүүлэхэд эхний ээлжинд шаардагдах 130 сая долларын хөрөнгө оруулалтыг БНХАУ-ын засгийн газрын хөнгөлттэй зээлэнд хамруулахаар нэг жилийн хугацаатайгаар санамж бичигт гарын үсэг зурлаа.



Захирамжлалын он сар өдөр, дугаар: 2014 оны 01 сарын 16 өдөр А/16

Томилолтын арга хэмжээний нэр: Хүй долоон худгийн ашиглалт хамгаалалттай холбоотой морин тойруулга, асар майхан, машин техникийн судалгаа

Явсан газар: БНСУ Сөүл хот

Хугацаа: 2014 оны 01 сарын 19 өдрөөс 2014 оны 01 сарын 23-ны өдрийн хооронд

Зардал: Улаанбаатар хотын төсвөөс

Зорилго: Солонгос улсын үндэсний өв соёлтой танилцах, Цогцолбор спортын төвүүд стадионы судалгаа, Морин тойруулга үзэж судлах, Хүй долоон худагт ашиглагдах машин техникийн үнэ, Асар майхан судалгаа хийх.

Үйл ажиллагаа: 2014 оны 01 сарын 20 өдөр Намянсон арал руу шууд очлоо. Төлөвлөгөөний дагуу энэ хотын аялал жуулчлал түүний хөгжил түүх өв соёлоо хэрхэн авч яваа бусдад хүргэж буй байдалтай танилцав. Өвлийн цагт аялал жуулчлалын бүсэд хэрэглэгдэж байгаа асар майханы талаар судалж танилцлаа.

2014 оны 01 сарын 21 өдөр Чунчон хотоор орж танилцлаа. Энэ хот бүхэлдээ аялал жуулчлал, амралтын бүс болсон Солонгос орны түүх өв соёл, байгалийн үзэсгэлэнт газруудын цогц болсон газар юм.

Нийслэлийн Сөүл дэх төлөөлөгчийн газрын төлөөлөгчийн хамт Чунчон хотоор тойрч сонирхож болох үзэсгэлэнт газрууд жуулчны баазууд тэдгээрийн үйлчилгээг сонирхож судаллаа. Өвлийн зориулалттай асар майхныг үзэж судаллаа. Асар майхан нь дотроо маш тохитой дулаахан хүй долоон худагт ашиглаж болох, хэрэгжүүлж болохоор зүйлийг судлав./зураг 3,5/

2014 оны 01 сарын 22-ний өдөр Сөүл хотод ирж Сөүлийн морин тойруулгыг үзэж морин тойруулгын ерөнхийлөгч болон удирдлагуудтай уулзаж туршлага солилцлоо. Сөүлийн морин тойруулга нь Солонгосын томоохон морин тойруулгын нэг бөгөөд энэхүү уулзалтаар морин тойруулгын удирдлагуудтай уулзаж морин тойруулгыг монголд хөгжүүлэх хүй долоод морин тойруулгатай болох цаашид хамтран ажиллах монголд ирж нийслэлийн удирдлагуудтай уулзаж хамран ажиллах талаар санал солилцов. /зураг2/

Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын 2014 оны тайлан, гүйцэтгэл

2014 оны 01 сарын 23 өдөр Инпеон дүүргийн удирдлагуудтай уулзаж санал солилцож туршлага судаллаа. Тус уулзалтаар Монгол наадам цогцолбор газрын тухай, байгууллагын цаашдын хөгжлийн талаар танилцуулж туршлага солилцлоо.

Үүний дараа Пусан хотын төлөөлөгчидтэй уулзаж машин техникийн талаар судалж танилцлаа. Машин механизмын хангалт тэдгээрийн экспортын талаар судалж ярилцав.





Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2014 оныдугаар
сарын-ний өдрийн дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

Монгол наадам цогцолборын Хүй долоон худагт олон нийтийн арга хэмжээ зохион
байгуулахад мөрдөх үнэ тариф

№	Үйлчилгээний нэр төрөл		Хэмжих нэгж	Үнэ тариф
1	Баяр наадам, бусад арга хэмжээ	Энгэрийн тэмдэг хаяг	1 ширхэг	3000
		Ариутгалын хураамж	м2	600
2	Хог хаягдлын хураамж	Аж ахуй нэгж байгууллага	1 өдөр	2500
		Түргэн үйлчилгээний цэг	1 өдөр	2500
		Сүүдрэвчтэй худалдаа	1 өдөр	2500
		Уяачид	1 өдөр	2500
		Бусад жижиг худалдаа	1 өдөр	2500
		Хоолны газрын үйлчилгээ	1 өдөр	2500
3	Цахилгааны хураамж	Төрөл бүрийн ахуйн хөргөгч	тус бүр	4000
		Төрөл бүрийн ус буцалгагч, будаа агшаагч	тус бүр	4000
		Төрөл бүрийн үйлчилгээний хөргөгч	тус бүр	7000
		Халуун тогоо	тус бүр	4000
		Цахилгаан зуух/Плитка/	тус бүр	4000
		Шарах шүүгээ	тус бүр	4000
		Телевизор, хөгжим	тус бүр	4000
		Компьютер, принтер	тус бүр	4000
		Тайзны гэрэлтүүлэг чимэглэл	иж бүрдэл	5000
		Гэрэл	тус бүр	1000
		380В-ын төрөл бүрийн цахилгаан хэрэгсэл	тус бүр	15000
		Төрөл бүрийн хүүхдийн цахилгаанаар ажилладаг тоглоом	тус бүр	3000
4	Нийтийн бие засах газар	Хуушуурын тогоо	тус бүр	6000
		Контейнер ОО	1 хүн	200
		Зөөврийн ОО	1 хүн	200
5	Наадмын талбай ашигласны төлбөр хураамж	Модон ОО	1 хүн	200
		Гэр	Тус бүр	20000
		Майхан	тус бүр	8000
6	Сурталчилга аны самбарын хураамж	Асар	тус бүр	10000
		Сурталчилгааны самбар	1м2	80000